



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Ковид-19”-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/003/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Пагамдулам
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn

Аудитор: Ж.Бямбацогт
Утас: 261628 Цахим хаяг: baymbatsogtb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

КОВИД-19-ИЙН ЭСРЭГ
ВАКЦИНЖУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ
ДЭМЖИХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Г.БАЯСГАЛАН ТАНАА

2025.04.03 № 07/1360

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газраас зээлийн үлдэгдэл санхүүжилтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нэн ялангуяа анхан шатан дахь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлээр зарцуулах хүсэлт гаргасны дагуу Азийн хөгжлийн банкны Захирлуудын зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар APVAX төслийн хамрах хүрээг өөрчлөн баталж, Ковид-19-ийн цар тахлын үед тасалдсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Аудитын гол асуудал

Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төслөөс 2024 онд Эрүүл мэндийн даатгалын санд 69,082,931.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн анхан шатны лавлагаа тусламж үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрт зориулж олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн үйл ажиллагаа 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр дуусч, зээлийн данс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хаагдахаар Зээлийн гэрээнд тусгасан байсан боловч үлдэгдэл төсвийг дахин хуваарилалт хийж, зарцуулах шийдвэрийн дагуу хугацааг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,456,323,000.00	192,238,800.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,456,323,000.00	192,238,800.00
31211	Төрийн сангийн харилцах	-	192,238,800.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	19,456,323,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,456,323,000.00	192,238,800.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	77,516,261.67	78,628,561.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	77,516,261.67	78,628,561.67
41360	Бусад өглөг	77,516,261.67	78,628,561.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,378,806,738.33	113,610,238.33
51	Засгийн газрын хувь оролцоо	19,378,806,738.33	113,610,238.33
51200	Хуримтлагдсан үр дүн	19,378,806,738.33	113,610,238.33
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,516,261.67)	19,378,806,738.33
51220	Тайлант үеийн үр дүн	19,456,323,000.00	(19,265,196,500.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,456,323,000.00	192,238,800.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,456,323,000.00	50,009,483,305.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	50,009,483,305.07
120	Нийтлэг татварын бус орлого	-	50,009,483,305.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	50,009,483,305.07
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		50,009,483,305.07
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	69,130,943,268.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	69,130,943,268.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	69,130,943,268.16
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	69,130,943,268.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	69,130,943,268.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	19,456,323,000.00	(19,121,459,963.09)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	143,736,536.91
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	143,736,536.91
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	19,456,323,000.00	(19,265,196,500.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	69,321,558,099.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	69,321,558,099.16
120	Нийтлэг татварын бус орлого	-	69,321,558,099.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	69,321,558,099.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	69,465,806,305.07
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	69,129,319,299.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	69,129,319,299.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	69,129,319,299.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
210101	Үндсэн цалин	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	69,129,319,299.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	69,129,319,299.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	192,238,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	192,238,800.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	192,238,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	(77,516,261.67)	(77,516,261.67)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	(77,516,261.67)	(77,516,261.67)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	19,456,323,000.00	19,456,323,000.00
11	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	19,378,806,738.33	19,378,806,738.33
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	(19,265,196,500.00)	(19,265,196,500.00)
20	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	113,610,238.33	113,610,238.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,315,600,000.00	69,129,319,299.16	186,280,700.84	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	69,315,600,000.00	69,129,319,299.16	186,280,700.84	99.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,315,600,000.00	69,129,319,299.16	186,280,700.84	99.7
Цалин, хөлс болон нэмэгдэл ура	-	-	-	-
Үндсэн цалин	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,315,600,000.00	69,129,319,299.16	186,280,700.84	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,315,600,000.00	69,129,319,299.16	186,280,700.84	99.7
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
Бусад хөрөнгө			-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,315,600,000.00	69,321,558,099.16	(5,958,099.16)	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,315,600,000.00	69,321,558,099.16	(5,958,099.16)	100.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	69,315,600,000.00	69,321,558,099.16	(5,958,099.16)	100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 19,503,823.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Замд яваа мөнгөн хөрөнгө 19,456,323.0 мянган төгрөгийн эхний үлдэгдлийг тайлант оны мөнгөн гүйлгээний тайланд орлогоор тайлагнаагүй	1	19,456,323.0	1	19,456,323.0			1	19,456,323.0				
2	ҮАГ-тай аудит хийлгэхээр 2024 оны 12 сарын дугаартай байгуулсан гэрээний аудитын үйлчилгээний төлбөр 47,500.0 мянган төгрөгийг өглөг дансанд бүртгэж тайлагнаагүй	1	47,500.0	1	47,500.0			1	47,500.0				
3													
Дүн		2	19,503,823.0	2	19,503,823.0			2	19,503,823.0			-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/